

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 02 -р сарын 19-ны өдөр

№ А/04-Т


Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9.6.18 дахь заалт, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.16 дахь заалт, болон “Ногдол ашгийн бодлого”-ын 3.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2020 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 1,219,374,606 (нэг тэрбум хоёр зуун арван есөн сая гурван зуун далан дөрвөн мянга зургаан зуун зургаан) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай;
2. Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 17 (арван долоон) төгрөгөөр тогтоосугай;
3. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөр тогтоосугай;
4. Энэхүү тогтоолын 2-т заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Компанийн хувьцаа эзэмшигчдийн дансанд олгосугай;
5. Энэхүү шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА


Б. АНХБОЛД